

ХАДНЫ ЗУРАГ ДАХЬ ОРООМОГ ДҮРСНИЙ УТГА, БЭЛГЭДЛИЙН ТУХАЙ

Ч.ЭНХТӨР, Ц.МӨНХБАТ

Ховд аймгийн Манхан сумын бүрэн дунд сургууль

e-mail: munkhbat_22@yahoo.com

ТҮЛХҮҮР ҮГ: *Хадны зураг, ороомог дүрс, Ховд аймаг, Манхан сум*

ТОВЧ АГУУЛГА: Энэхүү өгүүлэлд Монгол Алтайн нурууны төв хэсгээс шинээр илэрсэн хадны зургуудад тохиолдож байгаа **ороомог дүрсний** тухай болон буган хөшөө, хадны зургаадад тохиолддог ороомог дүрсний утга зүйн талаар өөрсдийн саналыг дэвшүүлж байна. Уг дүрслэл нь нүүдэлчдийн соёл, шашин, уламжлал, зан заншил, ертөнцийг үзэх үзэлд нэвт шингэсэн байх ба хадны зурагт ховор, харин буган хөшөө, Пазырык булинаас гарсан эд өлгийн зүйлс, Хүннүгийн ширмэл ширдэг зэрэгт нар зөв болон нар буруу эргэсэн байдлаар нэлээд дүрслэгджээ. Эл дүрслэлийн утга зүй бэлгэдлийг янз бүрийн соёлд өөр өөрөөр тайлбарласан ба ихэнхдээ үхэл, амьдрал, мөн нарыг бэлгэдсэн дүрслэл хэмээн үзэж байгаа бол бидний зүгээс хүний толгойн орой болон гар хөлний хурууны өндөгт байх эргүүлгийг бэлгэдсэн болов уу? хэмээн үзэж байна.

Хадны зураг бол хүн төрөлхтөний оюуны сэтгэлгээний анхны бүтээл төдийгүй бичгийн дурсгалтай эн зэрэгцэх түүхэн сурвалжийн нэг юм. Учир нь бичиг үсэг үүсэхээс өмнөх үеийн зургууд нь тухайн үеийн хүмүүс хэрхэн аж төрж юу бодож сэтгэж хүсэж мөрөөдөж байсан талаарх үнэтэй мэдээллийг агуулж буй түүхийн дурсгал болохоос гадна эртний хүмүүсийн шүтлэг бишрэл урлаг соёл оюун санааны шууд илэрхийлэл болно. Дэлхийд өргөн тархсан соёлын нэгэн үзэгдэл, эртний хүмүүсийн оюун санааны өвөрмөц дурсгал хадны зургийн дурсгалаар баялаг газрын нэг нь Монгол Алтайн нуруу билээ. Иймд Алтайн нуруунд байх олон мянган хадны зургийн дурсгалыг ЮНЕСКО-ийн дэлхийн соёлын өвд бүртгэн авсан байдаг.

Монгол Алтайн нурууны хадны зургийн агууламж, хэв загвар, зохиомж нь эртний хүмүүсийн ертөнцийг үзэх үзэл, амьдралын

хэв маяг, нийгмийн зохион байгуулалт болон тэдний амьдарч байсан байгалийн өвөрмөц нөхцөлөөс үүдэлтэй. Хадны зургийн сэдэв, зохиомж, дүрслэлийн арга барил өөр өөр байдаг нь он цаг хийгээд түүнийг бүтээсэн ард түмний оюун сэтгэлгээний онцлог ба нийтлэг талыг илэрхийлж байдагт оршино.

Бид 2012 онд Ховд аймгийн Манхан сумын төвөөс баруун зүгт 25 км-ийн зайд Улаан Хүрээ багийн нутагт орших Хүрэн дэлийн нуруунаас шинээр 300 гаруй хадны зургийн дурсгалыг олж илрүүлсэн ба эдгээр зургуудыг дараагийн дугаарт тусгайлан хэвлэх болно.

Хүрэн дэлийн хадны зургууд нь Х.Ө. 47° 15. 664", З.У. 092° 01. 223" солбицолд д.т.д 1700м өндөрт оршино. Уг хадны зургуудын дотор сонирхол татахуйц нэгэн дүрслэл байгаа нь дэлхий нийтийн археологийн соёлд неолитийн үеэс тархсан

хэмээн судлаачид үздэг **Ороомог (спираль) дүрс** юм (Зураг 1, 2). 2013 онд МҮМ-гээс эрхлэн гаргадаг “Нүүдэлчдийн өв судлал” сэтгүүлд судлаач Ж.Баярсайхан Хөвсгөл аймгийн Ренчинлхүмбэ сумын Тарган нуурын ар биеэс олж илрүүлсэн гурван буган хөшөөний дүр дүрслэл, утга зүйг тайлбарласан чамбай өгүүлэл хэвлүүлсэн. Энэ өгүүлэлд Тарган нуурын 2 дугаар хөшөөнд дүрслэгдсэн хоёр бүтэн эргэлттэй ороомог дүрсийг хилийн чанад болон Монголоос олдсон ороомог дүрслэлтэй дурсгалуудтай харьцуулсан өгүүллийг уншаад доорх бэсрэг өгүүллийг бичих санаа төрсөн юм.

Бид энэ удаад Хүрэн дэлийн нуруунаас илэрсэн ороомог дүрс хийгээд уг дүрсний бэлгэдэл утга зүйг



Зураг 1. Хүрэн дэлийн ороомог дүрс

судлаачид хэрхэн авч үздэгийг тодруулахын дээр өөрсдийн тайлбар таамаглалыг дэвшүүлж байна.



Зураг 2. Янгирын эврийг ороомог дүрсээр сийлсэн нь (Хүрэн дэл)

Монгол нутаг дахь ороомог дүрс сийлэгдсэн дурсгалууд

Монгол нутгаас илэрсэн хадны зурагт ороомог дүрсийг ховор сийлсэн, харин буган чулуун хөшөөдөд ороомог дүрсийг цөөн тоогоор сийлэн үлдээсэн байна. Жишээ нь: Ховд аймгийн Мөст сумын Баянзүрх уулын Мухар давын амны I буган хөшөө (Баярхүү, Төрбат, 2010: 93), Баян-Өлгий аймгийн Алтанцөгц сумын Хондлойн буган хөшөө (Төрбат нар, 2009: 48), Увс аймгийн Зүүнхангай сумын Хүрдлэгийн амны буган хөшөө (Нямбат, Одбаатар, 2010:57-66), Хөвсгөл аймгийн Арбулаг сумын Сүртийн хөндийгөөс археологич Д.Эрдэнэбаатар илрүүлэн олж эдүгээ Монголын үндэсний музейд хадгалагдаж буй нэгэн буган хөшөө, Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын Тарган нуурын II хөшөө (Баярсайхан, 2013: 67) зэрэг 6 буган хөшөөнд ороомог дүрс сийлэгдэн үлджээ. Ороомог дүрс сийлэгдсэн буган хөшөөдийг газарзүйн байршлаар авч үзвэл Монгол Алтайн өвөр бэлд 3, Увс аймагт 1, Хөвсгөл аймагт 2 бүртгэгдээд байна. Уг дүрс хөрш зэргэлдээ орнуудын нутагт буй буган хөшөөд дээр дүрслэгдсэн тохиолдол тун ховор байна.



Зураг 3. Хүрдлэгийн амны буган хөшөөн дээрх ороомог дүрс, гар зураг (Нямбат, Одбаатар, 2010)

Эл дүрслэлийн байрлал болон ороомогийн эргэлтийг нарийвчлан дурдвал, Мухар давын 1 дүгээр буган хөшөө, Хондлойн буган хөшөө, Сүртийн хөндийн буган хөшөө зэргийн баруун хажууд нар зөв эргэлттэй, харин Хүрдлэгийн амны буган хөшөөний баруун хажууд нар буруу

эргэлттэй ороомог дүрсийг сийлсэн байна (Зураг 3). Тарган нуурын 2 дугаар хөшөөний ороомог дүрс нь зөвхөн хоёр бүтэн эргэлттэй юм (Баярсайхан, 2013: 67).

Ороомог дүрслэлийг тайлбарлах нь

Судлаачид ороомог дүрсний утга учрыг олон янзаар тайлбарласан байдаг. Монголын үндэсний музейн эрдэм шинжилгээний ажилтан, доктор Ц.Одбаатар буган чулуун хөшөөн дээр дүрслэгдсэн ороомог дүрсийг Цагаан салаагийн хадны зурагт нэгэн хүний цаад талд дүрсэлсэн олон давхар цагираг бүхий дугуй дүрсэнд тулгуурлан "Бамбай" байж болох юм хэмээн үзсэн байдаг (Нямбат, Одбаатар, 2010: 60).


Судлаач Ц.Төрбат, Н.Баярхүү нар Хондлойн болон Мухар давын амны 1 дүгээр буган хөшөөнд бүсний дор бөгөөд баруун хажуу талд адил эргэлттэй, адил дүрсийг мөн адил аргаар дүрсэлсэн нь сонирхолтой хэмээн өгүүлжээ (Баярхүү, Төрбат, 2010: 94). Ганц нэг тохиолдлыг эс тооцвол, буган хөшөөний баруун хажууд дүрслэгдсэн ороомог дүрс ихэнхдээ нар зөв эргэлттэй, зүүн хажуу талд нар буруу эргэлттэй байна (Баярсайхан, 2013: 66).



Зураг 4. Ноён уулын 6 дугаар булнаас гарсан малгай (Баярсайхан, 2013)

Үүнтэй төстэй нэгэн баримт дурдахад, Ноён уулын 6 дугаар булнаас гарсан үслэг малгайн дээр хоёр ороомог дүрсэлсний баруун талынх нь нар зөв эргэлттэй, зүүн талынх нь нар буруу эргэлттэй байна (Руденко, 1962: таб. LXX, Зураг 4). Энэ малгайг зарим судлаачид

бөөгийн малгай хэмээн таамагласан ч бий (Пүрэв, 1999: 183).




Зураг 5. Ноён уулын 6 дугаар булнаас гарсан ширмэл ширдэг (Баярсайхан, 2013)


Мөн уг булнаас гарсан ширмэл ширдэг дээр ороомог дүрс олон байдаг (Руденко, 1962: Рис 48). Энэхүү ширмэл ширдэгний голын дөрвөлж дотор өргөөш 3 эгнээ, уртааш 8 эгнээ болгон нийт 24 ширхэг ороомог дүрсийг гурав гурваар нь сөөлжүүлэн нар зөв болон буруу эргэлттэйгээр дүрсэлжээ (Зураг 5). Өөрөөр хэлбэл нар зөв эргэлттэй 12, нар буруу эргэлттэй 12 ороомогийг урлан гаргажээ. Энэ нь Хүннү нарын чимэглэх урлагийн нэгэн илэрхийлэл болохоос гадна бүх зүйлийг бэлгэдлийн үүднээс бүтээдэг нүүдэлчдийн уламжлалын хувьд дүрсийн бэлгэдлийн агуулга бас хадгалагдаж байгаа нь тодорхой юм.

Хүннүгийн ширмэл ширдэг дээрх эдгээр ороомог дүрсүүдийг зарим судлаачид "Түмэн наст хээ"-ний нэгэн төрөл хэмээн үздэг (Ядамжав, 1985: 20). "Түмэн наст хээ"-г урт удаан, өнө орших, төгсөшгүй үргэлжлэхийн бэлгэдэл болгон дээдэлдэг. Магадгүй энэ утгаараа ч Хүннүгийн ширдэг дээр урлагдсан байж болох юм. Ямар ч атугай буган хөшөөдөд сийлсэн ороомог дүрслэл нь Монголчуудын өвөг дээдэс болох Хүннүчүүдийн ноёлох ангийнханд уламжлагдан үлдсэн байжээ. Үүнээс гадна нүүдэлчдийн язгуурын шүтлэг болох бөө мөргөлийн эд хэрэглэгдэхүүн дотор энэхүү ороомог дүрслэл бас тааралдаж байна. ОХУ-ын Эрхүү хотын музейд хадгалагдаж буй 19 дүгээр зууны сүүл 20 дугаар зууны эхэн

үсийн буриад бөөгийн даавуун дээр гурван ертөнцийг зурж дүрсэлсэн онгон зураг дээр дээд ертөнцийн од эрхэсийн дотор хоёр том дугуй нарны дүрслэл байгаагийн нэг нь олон давхар битүү цагиргуудыг давхарлан зурж гадагш богинохон нарны цацраг зурсан байхад нөгөөг нь нар буруу эргэлттэй ороомог дүрсээр зурж, гадагш нь цөөн тооны богино цацраг урлан гаргажээ (Баярсайхан, 2013: 68; Зураг 6).



Зураг 6. Буриад бөөгийн онго (Баярсайхан, 2013)



Зураг 7. Хорийн охидын онго зураг (Баярсайхан, 2013)

Хамгийн сонирхолтой нь энд хоёр нар дүрслэхдээ нэгийг нь битүү цагиргаар, нөгөөг нь ороомог байдлаар дүрсэлснээс гадна, хоёуланд нь цацраг дүрсэлсэн явдал юм. Хэрэв нэг нь цацраггүй байсан бол сар хэмээн үзэж болмоор. Гэвч бөөгийн өөр нэг даавуун дээрх “Хорийн охидын онгод” зураг

дээр мөн л хоёр нарыг олон давхар битүү цагирагаар дүрсэлж, хоёуланг нь голоос гадагш нэвт гарсан цацрагтайгаар дүрсэлсэн байгаа нь дээрх дүрсүүдээр нарыг төлөөлүүлсэн нь тодорхой байна (Зураг 7).

Бөөгийн хэрэглэгдэхүүнд байгаа эдгээр дүрсний адил олон давхар битүү цагирагтай, гадагш цацрагтай нарны дүрс манай улсын Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг Жавхлант хайрханы хадны зурагт олноор дүрслэгдсэн байдаг (Цэвээндорж нар, 2004).

Ороомог дүрслэл гадны соёлд

Ороомог дүрслэлийн бэлгэдэл нь үндэстэн угсаатан бүрт өөр өөр байсан бололтой. Гэхдээ нийтлэг ойлголт нь амьдрал, үхэл, эргэн төрөлтийн бэлгэдэл байхын зэрэгцээ нарыг бэлгэдэх нь бас тохиолддог.

Энэтхэг болон Пакистаны эртний соёлд ороомог дүрсийг эхийн ариун умай буюу үржлийн бэлэгдэл, бас хамгаалалтын бэлэгдэл, Грек, Ромын соёлд бурхад, сүнсний бэлэгдэл, Хятадад нарны шүтлэгтэй холбон үздэг бол Полинезийн арлын эртний хүмүүс үхэл, амьдралтай холбон бэлгэддэг аж.

Европын Келтүүдийн үлдээсэн мегалитын үеийн дурсгалуудын дотор бунхант булшны үүдэвч болон тахилгын газрын ойролцоох хад чулуун дээр янз бүрийн ороомог дүрсүүд сийлсэн байдаг. Үүнийг зарим судлаачид зөв эргэсэн ороомог нь нар болон газар дэлхийн зохицлыг, нар буруу эргэлтэй нь эртний сүсэг бишрэл дэх байгалийн хүч энергийг бэлгэддэг бололтой хэмээн тайлбарладаг бол зарим нь Келтийн ихэнх ороомог дүрс бунхант булш юм уу тахилгын газрын хажууд байгаа нь муу муухай сүнс, чөтгөрөөс өөр ертөнц рүү зорчигч хэн нэгнийг хамгаалах нууц хүчний бэлгэдэл болдог хэмээн үздэг байна. Мөн нар зөв эргэлтэй ороомгийг ус, хүч, овог аймгуудын нүүдэлтэй холбон үзэх хандлага ч бас бий. Үүнээс гадна, нар зөв эргэлттэй

ороомог нь өвлийн нар, нар буруу эргэлттэй нь зуны нарны төлөөлөл гэж бас үздэг.

Америкийн Индианчуудын хувьд ороомог дүрсээр улирлын ээлж, төрөх үхэх буюу амьдралын тойргийг төсөөлдөг ажээ. Тухайлбал, Америкийн Нью Мексико мужийн нутаг дахь Чако хавцлын Фажада хэмээх эгц өндөрлөг дээр ойролцоогоор 900-1300 оны үед зурж үлдээсэн ороомог дүрслэлийг судлаачид олон жил судалсны эцэст хавцлын хананд зурсан уг дүрслэл дээр хавцлын зайгаар тусах нарны гэрлийн тусгалаар улирал, зун, өвлийн нарны идэвхжил, өдөр шөнийн тэнцэл зэргийг тодорхойлдог байсан болохыг тогтоожээ (Sofaer, Sinclair, 1983; дам ишлэл Баярсайхан, 2013: 68).

Ороомог дүрс нь дорно дахинд Японы шинэ чулуун зэвсгийн үеийн МЭӨ 1300-900) Жомоны соёлын эрт, дунд, хожуу шатны ваар савууд (Баярсайхан, 2013: 68), Хятадын Шар мөрний сав дахь Неолитын үеийн Яншаогийн соёлын (МЭӨ 5000-3000 жил) ваар савууд (Кашина, 1977), Алс дорнодын Амар мөрний сав дахь Неолитын үеийн (МЭӨ 5000-3000 жил) ваар савууд (Окладников, 1984) дээр дүрслэгдсэн байна. Монгол болон Оросын Алтайд малтан судалсан Пазырыкийн дурсгалуудаас ороомог дүрслэлтэй ваар цөөнгүй олдсон байдаг.

Буган хөшөөн дээрх ороомог дүрсийг судлаач Ж.Баярсайхан Төв Азийн эртний хүмүүсийн нарны бэлэгдэл хийгээд бөө мөргөлийн ойлголттой холбон аливаа муу муухай зүйлээс хамгаалах, мөн амьдралын мөнхийн эргэлт, үхэх, төрөх хорвоогийн жамыг давхар агуулсан байж болох юм хэмээн үзсэн (Баярсайхан, 2013: 69).

Ороомог дүрсийн талаар бидний бодол

Ороомог дүрс гэдэг нар зөв болон буруу эргэсэн цагираг дүрс юм. Бид уг дүрсийг хүний гар, хөлний хурууны өндөг (Зураг 9), мөн толгойн оройд байх эргүүлгийг

төлөөлүүлсэн дурсгал байж болох юм хэмээн таамаглаж байна.



Зураг 8. Хүний хурууны хээ

Зөвлөлтийн нэрт Монголч эрдэмтэн Л.Н.Гумилев Монголчуудын түүхэн дэх мандан бадралт, бууралтыг тайлбарласан “Эрчим хүчний тэсрэлийн” онол (Гумилев, 2005) Монголчууд 300 гаруй жилийн давтамжтай тэнгэрээс болон газраас ихээхэн эрчим хүч авдаг, энэ хүчээ авсан үедээ хүчирхэгжин, харин эрчим хүч авч чадаагүй үедээ сулран доройтож, өөр хоорондоо тэмцэлдэн харийн гүрний (жишээлбэл, Манж чин гүрний) эрхшээлд ордог хэмээн үздэг. Энэ онолын үүднээс авч үзвэл Монголчууд тодорхой цаг хугацаанд биеийн аль нэг хэсэг, ямар нэгэн эрхтнээрээ тодорхой энерги, эрчим хүчийг өөртөө дамжуулан авдаг байх нь. Тэгэхээр энэ энерги, эрчим хүчийг хаанаас, хэзээ, юугаар дамжуулж авдаг байсан бэ? Одоо тэр эрчим хүчийг бид авч байгаа юу? гэсэн асуулт өөрийн эрхгүй урган гарч ирнэ. Энэ асуултанд хариулахын тулд бөөгийн шашны болон угсаатны зүйн баримтуудыг авч үзэхийг хүсч байна.

Монголчууд эртнээс нааш хаана хэрхэн хийморио сэргээдэг байсныг тодруулбал **Нэгд**, Уул овоон дээрээ очиж, **Хоёрт**, Ургахын улаан нарнаас, **Гуравт**, Газар эх этүгэн - ээс эрчим хүч авч хийморь сүлдээ сэргээдэг байжээ. Тодруулбал:

Нэг. Уул овоог тахиx, галыг эрхэмлэх зан үйл. Монголчууд эртнээс нааш бөөгийн шашны уламжлалаар уул овоогоо тахиж, шүтсээр ирсэн. Өдгөө ч ийм зан үйлүүд бурхны шашинд бат бөх байсаар байна. Жишээ нь, шинийн нэгний өглөө уул

овоондоо идээ цагаагаа өргөдөг ба энэ овоогоо наран мандах зүг хандуулан өндөр довцог газар дээр босгодог. Мөн жил бүр нутгийн шүтлэгтэй овоог лусын буулт буух өдөр тахин аргадаж, бороо хур оруулахыг хүсдэг зэрэг нь бүгд бөөгийн зан үйл юм.

Монголчууд жижиг овооноос авахуулаад төрийн тахилгат уул овоог өндөр уулын орой довцог газар барьдаг нь бөөгийн зан үйлийн үүднээс дээд тэнгэрээс ирж байгаа эрчим хүч тэр газар буудаг хэмээх үзэлтэй холбоотой бололтой. Монголын нууц товчоонд Чингис хаан 1219 онд Хорезм улс эзэнт гүрний алтан аргамж болсон элчийн харилцааг удаа дараа тасалсан учир дайн зарлахаас өөр аргагүйд хүрч аян дайнд мордохын өмнө “Бурхан халдун” уулан дээрээ гарч малгайгаа авч бүсээ хүзүүндээ өлгөн гарынхаа алгыг дээш харуулан гурван өдөр гурван шөнө тэнгэр газартайгаа харьцаж (Паламдорж., Мягмарсамбуу, 2006: 125) дуусаад баруун хөдөлсөн тухай гардаг. Зохиолч Ч.Лодойдамба “Тунгалаг тамир” романдаа Итгэлт баяны хүү Хонгорыг Шилийн богд уулан дээр гарч урьдын шилийн сайн эрчүүдийг магтан дуулж, хийморио сэргээгээд шилийн сайн эр болж буйгаар бичсэн нь бас учиртай. Харин өнөө цагийн төв Монголын иргэд “Хийморийн овоо” гэж нэрлэсэн овоог бий болгож хийморио сэргээхийн тулд (тэр жилийн энергийг авахын тулд) шинийн нэгний өглөө эртлэн овоон дээрээ очин гал түлж тусгай зан үйл үйлддэг болжээ.

Гал түлэх зан үйл нь Монголын өнцөг булан бүрт байдаг түгээмэл зан үйл юм. Гал түлж байгаа нь эрчим хүч буух газрын ойр орчим байх муу муухай зүйлийг хөөн зайлуулж буй бөө мөргөлийн зан үйл юм (Пүрэв, 1999). Монголчууд эртнээс галыг амьдлаг зүйл хэмээн үзэж ирсэн бөгөөд дундад зууны үед гадны элч төлөөлөгчдийг галын дундуур алхуулж, муу муухай зүйлийг арилгасны дараа хаанд бараалхуулдаг байсан (Карпини, 1988: 19). Өдгөө ч талийгаачийг нутаглуулсны дараа оршуулганд явсан хүмүүс хоёр галын

дундуур гарч ариусан гашуудлыг тайлдаг. Хоолныхоо дээжийг галд өргөж галын бурхан баярлуулах, бүтэн хонины өвчүү бүтнээр нь галд хийж гал тахих гэх мэт галыг эрхэмлэх зан үйл өдгөө ч монголчуудын дунд хадгалагдсаар байна.

Шинийн нэгний өглөө гал асааж тусгай зан үйлээ хийж байхдаа монголчууд малгайгаа авч, идээ будаагаа алган дээрээ тавин хурай, хурай, хурай хэмээн хурайлдаг нь тэнгэрээс ирж байгаа энергийг толгойныхоо оройн эргүүлэг, хурууныхаа өндөгний эргүүлгээр, харин газраас ирж буй энергийг хөлийн хурууны өндөгний эргүүлгээр өөртөө шингээн авч тэр жилдээ хийморь сүлд нь босоо явахыг ерөөж бэлгэдсэн зан үйл юм.

Хоёр. Нарыг эрхэмлэн тахих, нарнаас эрч хүч авах. Дэлхий нийтээр нарыг эртнээс нааш эрхэмлэн дээдэлсээр ирсэн ба Монголчуудад ч нартай холбоотой зан үйл маш олон байна. Жишээ нь, гэрлэх гэж байгаа хүний хадаг сүйг өгөх хүмүүс айлд өглөөний мандах нарнаар ордог, хурим хийхдээ охиныг шинэ гэрт нь дөнгөж нар мандаж байхад оруулдаг зан үйл өдгөө ч хүртэл бий. Захчин хуримын зан үйлд хурим хийж байгаа залуусыг гэрийн урд талд хонины арьс юмуу эсвэл ширдэг дээр суулган хадаг уясан чөмөгний том талыг нь залууд, нарийн талыг охинд атгуулаад

Шар наранд мөргөмүү

Шагай чөмгөнд мөргөмүү

Дөрвөн аав ээжийн заяа сахиусанд мөргөмүү?

хэмээн наранд гурвантаа мөргүүлдэг (Баасандорж нар, 2005: 135) байсан нь хурим хийж буй залуусыг ургах шар нартай адил гэрэл гэгээтэй амьдрахыг бэлгэдсэн бололтой.

Гурав. Газар (эх этүгэн) - аас эрчим хүчийг авах. Монголчууд газрыг *этүгэн* эх хэмээн шүтэж ирсэн ба газарт гадас, мод хатгаж орхихыг цээрлэдэг нь газрыг амьд хэмээн үзэж ирсэнтэй холбоотой. Хаврын эхэн сард лус сэргэсэн, ан амьтан ичээнээс гарсан хэмээн үзэж газар булаг шандтайгаа болгоомжтой харьцаж ирсэн байдаг.

Монголчууд хүүхдийг мөлхөх үеэс нь эхлэн гадаа шороонд тоглуулж, газартай харьцуулж эрүүл чийрэг хүн болгон өсгөдөг байсан. Монгол хүүхдүүд зуны гурван сар зориуд хөл нүцгэн явж газраас ирж байгаа энергийг биедээ шингээдэг байжээ. Энэ нь эртнээс нааш уламжилсан зан үйл бөгөөд бидний өвөг дээдэс газраас ямар нэгэн эрчим хүч ирж байдгийг мэдэж байсан учраас үр хүүхдээ үргэлжийн хөл нүцгэн байлгаж, газрын эрчим хүчийг авахуулдаг байсан бололтой.

ДҮГНЭЛТ

Манхан сумын нутгаас шинээр илэрсэн хадны зургууд дунд ороомог дүрслэл нэг, мөн нэгэн янгирын эврийг ороомог дүрсээр сийлсэн дурсгал илэрлээ. Ороомог дүрс нь 3000 жилийн тэртээгээс буган хөшөө, хадны зурагт тэмдэглэгдэж ирснээс үзэхэд уг дүрс бөөгийн зан үйлтэй салшгүй холбоотой болох нь мэдэгдэж байна.

Бидний таамгаар буган хөшөө, хадны зураг дээрх ороомог нь хүний толгойн оройн үсний эргүүлэг, гар, хөлний өндөгний эргүүлгийг дүрсэлсэн бөгөөд газар, тэнгэрээс ирж буй эрчим хүчийг хүний биед шингээн дамжуулах замыг бэлгэдсэн бололтой. Монголчууд уул овоон дээр гарах, ном судар уншуулахдаа үргэлж малгайгаа авч, алгаа дээш харуулан гараа дэлгэж залбирдаг нь эрчим хүчийг толгойн эргүүлэг, хурууны өндгөөрөө дамжуулан авч буй зан үйл бөгөөд эцэг, эхийн үгэнд ордоггүй танхай хүүхэддээ "Миний хэлсэн

үг, чиний толгойн оройгоор орох цаг ирнэ" хэмээдэг нь магадгүй толгойн оройд байх эргүүлгээр хэлсэн үг орно, улмаар энэ л эргүүлгээр хүн гаднаас эрч хүч энерги авна гэсэн утгатай бололтой.

Хүний толгойд байх үсний эргүүлэг дийлэнх хүмүүст нар зөв эргэсэн байдаг. Дээр өгүүлэн буй хоёр ороомог дүрс хоёулаа нар зөв эргэлттэй сийлэгдсэн нь утга зүйн хувьд бидний таамагтай нийцэж байна. Үүнээс гадна нар зөв эргэлттэй ороомог дүрс нь нүүдэлчдийн нарыг эрхэмлэх заншил, бүх зүйлийг нар зөв тойруулан хийдэг зан үйлийн нэг илрэл байж болох юм. Монголчууд гэрийн бүслүүрийг нар зөв тойруулан бүсэлдэг, дээл өмсөхдөө бүсээ нар зөв тойруулдаг, тоглоом наадам тоглохдоо хүртэл нар зөв эргүүлэн тоглодог уламжлалтай. Нүүдэлчдийн өдөр тутмын амьдралын үйл ажиллагаа нар, байгаль дэлхийтэйгээ салшгүй холбоотой, түүний хэмнэлээр явагддаг тул магадгүй нарны эргэлтийг даган аливаа зүйлийг нар зөв тойруулах зан үйлүүд бий болсон бололтой.

Нүүдэлчид НТӨ 3000 жилийн тэртээгээс эхлэн буган хөшөө, хад чулуунаа ороомог дүрсийг сийлдэг байсан нь хүний толгойн оройн эргүүлэг, гар хөлийн хурууны өндгөнд байх эргүүлгийг төлөөлүүлсэн дүрс байж болох бөгөөд уг дүрслэл нь эрчим хүчийг биед дамжуулах зам гүүр болон нэн эрт үеэс нааш түүхийн бүх үеүүдэд хэрэглэгдсээр ирснийг үгүйсгэх аргагүй юм. Гэвч цаашид энэ дүрслэлийн бэлгэдэл, утга зүйг нарийвчлан судлах шаардлагатай юм.

ТАЛАРХАЛ

Энэхүү өгүүллийг бичихэд харамгүй сэтгэлээр үнэтэй зөвлөгөө өгсөн Монголын үндэсний музейн эрдэм шинжилгээний төвийн дарга, багш Ж.Баярсайхан, МУИС-ийн багш М.Эрдэнэ, ХИС-ийн багш Ч.Мөнхбаяр нарт талархсанаа илэрхийлэхийн ялдамд цаашдын эрдэм судлалын ажилд нь өндөр амжилтыг хүсэн ерөөе.

НОМ ЗҮЙ

Баасандорж Ц., Очир А., 2005. Ойрад Монголчуудын хуримын зан үйл. XIX-XX зууны жишээн дээр. Улаанбаатар
Баярсайхан Ж., 2013. Тарган нуурын сав газраас шинээр илрүүлсэн буган хөшөөд. - Нүүдэлчдийн өв судлал, Том (XIV), Fasc 1-43. х. 61-77. Улаанбаатар.

- Баярхүү Н., Төрбат Ц.*, 2010. Монгол Алтайн нурууны өвөр бэлийн буган чулуун хөшөөд. - *Археологийн судлал*, Том (IX) XXIX, Fasc 1-21. х. 94-122. Улаанбаатар.
- Гумилев Л.Н.*, 2005. Этногенез и биосфера Земли. М.
- Карпини П.*, 1988. Монголчуудын түүх. УБ
- Кашина Т.И.*, 1977. Керамика культуры Яншао. Новосибирск.
- Нямбат М., Одбаатар Ц.*, 2010. Зүүнхангай сумын нутгаас шинээр олдсон буган хөшөөд. *Нүүдэлчдийн өв судлал*, Том (X), Fasc 1-23. х. 57-69. Улаанбаатар.
- Окладников А.П.*, 1984. Керамика древнего поселения Кондон (Приамурье). Новосибирск.
- Паламдорж Ш., Мягмарсамбуу Г.* 2006. Монголын нууц товчоо. УБ.
- Пүрэв О.*, 1999. Монгол бөөгийн шашин, УБ.
- Руденко. С.И.*, 1962. Культура хуннов и Ноинулинские курганы. М.-Л.
- Төрбат Ц., Баяр Д., Цэвээндорж Д., Баттулга Ц., Баярхүү Н., Идэрхангай Т., Жискара П.Х.*, 2009. Монгол Алтайн археологийн дурсгалууд-1: Баян-Өлгий аймаг. Улаанбаатар
- Цэвээндорж Д., Баяр Д., Цэрэндагва Я., Гүнчинсүрэн Б., Гарамжав Б.*, 2004. Жавхлант хайрханы хадны зураг. УБ.
- Ядамжав Ц.*, 1985. Монгол ардын хээ угалзын эх дүрсүүд. УБ.
- Sofaer AP, Sinclair RM.*, 1983. Astronomical Markings at Three sites on Fajada Butte. In: Carlson JB, Judge WJ. (Eds), *Astronomy and Ceremony in the Prehistoric Southwest*. Maxwell Museum of Anthropology, Anthropological Papers, No. 2. Published by Maxwell Museum of Anthropology.

SUMMARY

CH.ENKHTUR, TS.MUNKHBAT

SYMBOLICAL MEANING OF SPIRAL IMAGES IN THE PETROGLIPHS

The paper discusses about the newly discovered in the Huren Del mountain of the Altai mountain range, petroglyph with spiral image. The Huren Del mountain is located in Mankhan sum, Khovd province, Western Mongolia.

The spiral image is a common element in different cultures and carries various meanings. In many cultures, it symbolizes the sun, while in other countries, it is a symbol of womanhood.

We propose that spiral images depicted on the deerstones and petroglyphs symbolize fingerprint and hair rotation on the head, which might be commonly believed to be the bridge through which human accept and absorb energy from the sun and the universe.